

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА Л.БЯМБАСҮРЭН-  
ТАНАА

МОНГОЛ УЛС

УЛААНБААТАР ХОМ. НИИТ ЯАМ

Зам тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2019 оны 07-р сарын 31-ний өдөр /2019/07/31/

2019 07 31 - 02/4111

Тусгай захирамж

Тушаан хүргүүлэх тухай

Зам тээврийн салбарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг тайлагнах тухай Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 253 дугаар тушаал батлагдаад байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тэдгээрийг хэрэгжүүлэхээр батлагдсан дүрэм, журам, стандарт, үг тушаалд нийцүүлэн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван /3/ шатны хяналтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулан 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө баталж, боловсруулалтын явцад тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажиллана уу.

Мөн "Улаанбаатар томор зам" ХНН "Монголын төмөр зам" ТӨХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ болон уул, уурхай, эрчим хүчний салбарт гурав болон дөрөвд шатны хяналтын журмаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод хяналтыг тавьж ажилладаг тул эдгээр байгууллагын туршлагыг судлах нь зүйтэй.

Дээрх тушаалын 1.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд жишиг загвар болгож Иргэний нисэхийн ерөнхий газрын Газрын тусгай үйлчилгээний албаны Агаарын хөлгийн газрын үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгааны бүртгэлийн дэвтэр" ийг хавсаргав.

Дараах баримт бичгийг хэвсралтаар хүргүүлж байна.

- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 253 дугаар тушаалын хуулбар 2 хуудастай.
- "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтын дэвтэр"-ийн жишиг загвар 1 боть.

Иргэний нисэхийн ерөнхий газрын Газрын тусгай үйлчилгээний албаны Агаарын хөлгийн газрын үйлчилгээний хэлтсийн "ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгааны бүртгэлийн дэвтэр"-ийн жишиг загвар 1 боть.

ДЭД САЙД, ЗАМ, ТЭЭВРИЙН  
САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН  
САЛБАР ХОРООНЫ ДАРГА

Л.ХАЛТАР



МОНГОЛ УЛСЫН  
ЗАС, ТЭЭВРИЙН ХӨДӨЛМӨРИЙН  
САЙДЫН ТУШААХ

2019 оны 07 сарын 26 өдөр

Утас 253

Хувийн хэргийн

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах ажлын хүрээнд чиг үүрэгт хамаарах дараах үйл ажиллагааг зохион байгуулж, биелэлтийг тооцож, хяналт тавьж ажиллахыг харьяа байгууллагын дарга, удирдлагад үүрэг болгосугай. Үүнд:

1.1. Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, машин механизм, үндсэн болон суурин тоног төхөөрөмж, өргөх зөөх, тээвэрлэх механизм, даралтат сав, шугам, хоолой, эд анги, ажлын багаж хэрэгсэл зэргийг ашиглах, эзэмшихэд тавих шаардлага, тэдгээрийн техникийн баримт бичгийн хөтлөлт, төлөвлөгөөт засвар үйлчилгээг хугацаанд нь хийж ажилтныг аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх.

1.2. Эрүүл мэндийн үзлэгт зайлшгүй хамруулах шаардлагатай ажилтныг зохих журмын дагуу үзлэгт хамруулан үзлэгийн мөрөөр эрүүл мэндийг хамгаалж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулан мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлж, ажилтанд учирч болох эрсдлээс хамгаалсан байх.

1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссын ажлын явц, осолд дөхсөн тохиолдол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан нөхцөлийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч, ажилтнуудын ажил үүргийн хуваарилалт, ажил амралтын дэглэмийг мөрдүүлж осол зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан байх.

1.4. Ажилтны ажлын нөхцөл, онцлогт тохирсон ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслээр ханган, ажилтнуудад бүрэн ашиглуулж, тэдгээрийн хадгалалт, угаалга, цэвэрлэгээ, засвар, ариутгалыг хариуцаж, аюултай, хортой нөхцөлд ажилладаг ажилтныг хүнсний бүтээгдэхүүн, хор саармагжуулах бодисоор хангаж, ажил, үйлчилгээний явцад үүсэх хими, физик, биологийн хүчин зүйл нь ажилтны эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлж байгаа тохиолдолд багасгаж, бууруулсан байх.

1.5. Ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохих сургалтад хамруулж, шалгалт авч "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй, Сургалтын зохион байгуулалт, Үндсэн дүрэм" MNS 4969-2000 үндэсний стандартын дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын байрны онцлогт тохируулан тогтмол өгч, эрүүл, аюулгүй нөхцөлд ажиллах дадлыг ажилтан бүрт эзэмшүүлсэн байх.

418

08 734

10 07 11

1.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг жил бүр төсөвт тусган зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавих.

1.7 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн үзлэг, хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, түүний хэрэгжилтэд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгуулсан байх.

2 Энэхүү тушаалын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гураван /3/ шатны хяналтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулан баталж, хэрэгжилтийг хагас жил тутамд Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд тайлагнаж байхыг харьяа байгууллагын дарга, удирдлагад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд бөгөөд Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны дарга /Л Халтар /-д даалгасугай.

САЙД



Б.ЭНХ-АМГАЛАН

418

19-07 31

БАТЛАВ.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГА  
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ  
АХУЙН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨ  
ДАРГА Ё.ЭРДЭ



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2019 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДРИЙН  
“ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ” 253 ДУГААР ТУШААЛААР  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ


№	Өгсөн үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан
1.1.	НЭГ. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээврийн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, э ахуйн талаарх ажлыг эрчимжүүлж, хариуцлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд: Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, машин механизм, үндсэн болон суурин тоног төхөөрөмж, өргөх зөөх, тээвэрлэх механизм, даралтат суурин тоног төхөөрөмж, өргөх зөөх, тээвэрлэх механизм, даралтат сав, шугам, хоолой, эд анги, ажлын багаж хэрэгсэл зэргийг ашиглах, эзэмшихэд тавих шаардлага, тэдгээрийн техникийн баримт бичгийн хөтөлгөд үзлэг шалгалт хийх	1.1.1. тээврийн хэрэгсэл, машин механизм, үндсэн болон суурин тоног төхөөрөмж, өргөх зөөх, тээвэрлэх механизм, даралтат сав, шугам, хоолой, эд анги, ажлын багаж хэрэгсэл зэргийг ашиглах, эзэмшихэд тавих шаардлага, тэдгээрийн техникийн баримт бичгийн хөтөлгөд үзлэг шалгалт хийх	2, 5, 8 дугаар сард	Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл
1.2.	Эрүүл мэндийн үзлэгт зайлшгүй хамруулах шаардлагатай ажилтныг зохих журмын дагуу үзлэгт хамруулан үзлэгийн нөхцлийг бүтээж үүлсэн байх	1.1.2. төлөвлөгөөт засвар үйлчилгээг хугацаанд нь хийж буй эсэхэд хяналт тавьж үзлэг зохион байгуулах 1.2.1. Нийт ажилтныг Эрүүл мэндийн сайдын 340 дүгээр тушаалын дагуу урьдчилсан болон хугацаат үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	3, 6, 10 дугаар сард	Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл
1.2.	Эрүүл мэндийн үзлэгт зайлшгүй хамруулах шаардлагатай ажилтныг зохих журмын дагуу үзлэгт хамруулан үзлэгийн нөхцлийг бүтээж үүлсэн байх	1.2.1. Нийт ажилтныг Эрүүл мэндийн сайдын 340 дүгээр тушаалын дагуу урьдчилсан болон хугацаат үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	6 дугаар сард	Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл

	<p>мереер эрүүл мэндийг хамгаалж, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулан мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлж, ажилтанд учирч болох эрсдэлээс хамгаалсан байх</p>	<p>1.2.2. Үзлэгийн мөрөөр ажилтны эрүүл мэндийг хамгаалын тулд судалгаа гарган нарийн мэргэжлийн эмнэлгийн үзлэг эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах</p> <p>1.2.3. нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаанд хамруулах ажлыг зохион байгуулах</p> <p>1.2.4. мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ"-г мэргэжлийн байгууллагаар хийлгэх</p>	<p>Тайлант хугацаанд</p> <p>Тайлант хугацаанд</p> <p>8 дугаар сард</p>	<p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p>
1.3.	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссын ажлын явц, осолд дөхсөн тохиолдол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан нөхцлийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч, ажилтнуудын ажил үүргийн хуваарилалт, ажил амралтын дэглэмийг мөрдүүлж, осол зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан байх;</p>	<p>1.3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссын үйл ажиллагааг тасралтгүй үр дүнтэй явуулах ажлыг зохион байгуулах</p> <p>1.3.2. осолд дөхсөн тохиолдол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан нөхцлийг тодруулж, судалгаа гаргах</p> <p>1.3.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалт зохион байгуулах</p>	<p>Тайлант хугацаанд</p> <p>4 дүгээр сард</p> <p>Тайлант хугацаанд</p>	<p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p>
1.4.	<p>Ажилтны ажлын нөхцөл, онцлолт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр ханган, ажилтнуудад бүрэн ашиглуулж, тэдгээрийн хадгалалт, угаалга, цэвэрлэгээ, засвар, ариутгалыг хариуцаж, аюултай, хортой нөхцөлд</p>	<p>1.4.1. Ажлын нөхцөл, онцлолт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах</p> <p>1.4.2. ИНЕГ-ын даргын 2015 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/625 дугаар тушаалаар баталсан "Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, сүү, цэвэрлэгээ, үйлчилгээний материалын</p>	<p>Тайлант хугацаанд</p> <p>7 дугаар сард</p>	<p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p>

	<p>ажилладаг ажилтныг хүнсний бүтээгдэхүүн, хор саармагжуулах бодисоор хангаж, ажил, үйлчилгээний явцад үүсэх хими, физик, биологийн хүчин зүйл нь ажилтны эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлж байгаа тохиолдолд багасгаж, бууруулсан байх;</p>	<p>жагсаалт, эдэлгээний норм"-ыг шинэчлэх асуудалд санал оруулж тусгуулах</p> <p>1.4.3. "Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, сүү, цэвэрлэгээ, үйлчилгээний материалын жагсаалт, эдэлгээний норм"-ын хэрэгжилтэд хяналт тавих</p>	<p>3, 6, 9 дүгээр сард</p>	<p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p>
<p>1.5.</p>	<p>Ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохих сургалтад хамруулж, шалгалт авч, "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм" MNS 4969:2000 үндэсний стандартын дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын байрны онцлогт тохируулан тогтмол өгч, эрүүл, аюулгүй нөхцөлд ажиллах дадлыг ажилтан бүрт эзэмшүүлсэн байх;</p>	<p>1.5.1. Нийт ажилтны ХАБЭА-н сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулах</p> <p>1.5.2. "Үндсэн дүрэм" MNS 4969:2000 үндэсний стандартын дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын байрны онцлогт тохируулан тогтмолжуулж байгаад үзлэг шалгалт хийх</p>	<p>3 дугаар сард</p> <p>2, 5, 8 дугаар сард</p>	<p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p>
<p>1.6.</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг жил бүр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг жил бүр төсөвт тусгах</p>	<p>1.6.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг ХАБЭА-н тухай хуулийн 26.2 дахь заалтын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1,5 хувиас доошгүй байхаар ИНЕГ-ын жилийн төсөвт тусгуулах санал хүргүүлэх</p>	<p>7 дугаар сард</p>	<p>Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл</p>

1.7	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн үзлэг, хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, түүний хэрэгжилтэд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгуулсан байх	1.7.1. ХНХС-ын 114 дүгээр тушаалыг хэрэгжүүлж, шаардлагатай нэгжүүдэд ХАБЭА-н бүтэц байгуулах, орон тоог нэмэгдүүлэх 1.7.2. Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХАБЭА-н зөвлөлийн нэрэмжит үзлэг, шалгалт зохион байгуулах, гарсан үл тохирлыг арилгуулах үйл ажиллагааг зохион байгуулах	Тайлант хугацаанд  2, 5, 9 дүгээр сард	Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл  Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл
-----	---	---	--	--

Боловсруулсан: НБУГ-ын ГАБХХЭА хариуцсан инженер



Т.Төгсбаяр

ЧХОУНБ-ын ХХГАБ хариуцсан мэргэжилтэн



Б.Энхжаргал